



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 8/04

Хажуу шинэ ус

Бат-Амгалангийн Мөнхтөгөлдөрийг
ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 472 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 02 дугаар сарын 28-ний 05/2725 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бат-Амгалангийн Мөнхтөгөлдөрийг 2022 оны 03 дугаар сарын 16-ний өдрөөс эхлэн 1 дүгээр багийн Засаг даргын албан тушаалд томилсугай. Б.Мөнхтөгөлдөрт ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга	Д.Сарангэрэл (Засаг даргын орлогч)
Гишүүдэд	Л.Батбаатар (4 дүгээр багийн засаг дарга)
	Б.Алтансүх (Тамгын газрын нярав)

2. Б.Мөнхтөгөлдөрийг сарын үндсэн цалинг 603031 (Зургаан зуун гурав мянга гучин нэг) төгрөгөөр тогтоож зохих нэмэгдлийн хамт олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Уранбилэг)-т зөвшөөрсүгэй.

3. Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж ажиллахыг 1 дүгээр багийн засаг дарга (Б.Мөнхтөгөлдөр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН